

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал"-ын 4.5 дугаар зүйл, "Төв чандмань ДЭХГ" ОНӨААТҮГ-ын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 243 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "Төв чандмань ДЭХГ" ОНӨААТҮГ (Д.Баярбат)-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 153, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 04, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 183 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Төв аймгийн Зуунмод сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт байгууллага	Эзлэхүүнээр халаалт	Төг/м ³	3,600.0	
		Хэмжүүрээр халаалт	хувьсах	Төг/ГЖ	68,974.0
			тогтмол	Төг/м ³	1,790.0
		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м ³	5,370.0	
			Төг/хүн	6,270.0	

--oOo--

*Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ ӨРХӨД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Төв аймгийн Зуунмод сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	Эзлэхүүнээр халаалт		Төг/м ³	2,150.0
		Хэмжүүрээр халаалт	хувьсах	Төг/ГЖ	41,193.0
			тогтмол	Төг/м ³	1,069.0
		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Төг/м ³	5,370.0
Төг/хүн	6,270.0				
2	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "00" –ын өрөөний халаалт хамаарна)		Төг/м ²	1,400.0	
3	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Усны зарцуулалтаар	Төг/м ³	1,820.0
			Хүнээр	Төг/хүн	2,740.0

--oOo--